


## Ипотекийн зээлийн тайлан

2015 оны 12 дугаар сар


Банкууд 2015 оны 12 дугаар сард нийт 843 зээлдэгчид 46.8 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгосноор ипотекийн зээлийн үлдэгдэл 3433.0 тэрбум төгрөг, нийт зээлдэгчдийн тоо 77105-д хүрчээ.

Тайлант сарын эцэст ипотекийн зээлийн үлдэгдлийн жилийн өсөлтийн хурд өмнөх сартай харьцуулахад 2.9 нэгж хувиар, оны эхнээс 26.0 нэгж хувиар буурсан байна.



Тайлант сарын эцэст ипотекийн зээлийн үлдэгдлийн 75.5 хувь буюу 2591.0 тэрбум төгрөгийг “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээл (жилийн 8 хувийн хүүтэй зээл болон 8 хувийн хүүтэй зээлд шилжүүлсэн зээл), 22.6 хувь буюу 777.1 тэрбум төгрөгийг банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл, 1.9 хувь буюу 64.8

тэрбум төгрөгийг бусад эх үүсвэрээр олгосон зээл бүрдүүлж байна.



2015 оны 12 дугаар сарын байдлаар ипотекийн зээлийн үлдэгдлийн 98.7 хувь нь төгрөгийн зээл, 1.3 хувь нь гадаад валютын зээл байна.

Ипотекийн зээлийн үлдэгдэлд эзлэх хугацаа хэтэрсэн зээлийн хувь 2015 оны 12 дугаар сарын байдлаар 1.9 хувь, чанаргүй зээлийн эзлэх хувь 0.6 байна.



### Тайлант сард олгосон зээл

Тухайн сард олгосон ипотекийн зээл өмнөх сараас 32.3 хувиар, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 56.9 хувиар буурсан байна.



Тайлант сард шинээр олгосон зээлийн 70.7 хувь буюу 33.1 тэрбум төгрөг нь “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээл, 29.3 хувь буюу 13.7 тэрбум төгрөг нь банкуудын өөрийн эх үүсвэрээс олгосон зээл байна.



Нэг зээлдэгчид ногдох олгосон зээлийн хэмжээ 2015 оны 12 дугаар сарын байдлаар 55.6 сая төгрөг байна.

Тухайн сард 26.9 тэрбум төгрөгийн ипотекийн зээл төлөгдсөн нь өмнөх оны мөн үеэс 1.9 хувиар өсчээ.



### Зээлдэгчдийн тоо

Тайлант сард нийт 843 зээлдэгч шинээр ипотекийн зээлд хамрагдсанаас 612 зээлдэгч “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээлд, 231 зээлдэгч банкны өөрийн эх үүсвэрийн зээлд хамрагдсан байна.



2015 оны 12 дугаар сарын байдлаар нийт 77105 иргэн ипотекийн зээлтэй байгаагаас 55830 нь “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээлд, 19326 нь банкуудын өөрийн эх үүсвэрийн зээлд, 1949 нь бусад эх үүсвэрийн зээлд хамрагдсан байна.




### Зээлийн хугацаа

Тайлант сард банкууд 0.5-20 жилийн хугацаатай зээл олгосон бөгөөд жигнэсэн дундаж хугацаа нь 16.7 жил байна. Ипотекийн зээлийн үлдэгдлийн жигнэсэн дундаж хугацаа 2015 оны 12 дугаар сарын байдлаар 15.4 жил байна.

Тухайн сард олгосон зээлийн дийлэнх буюу 54.8 хувь нь 16-20 жилийн хугацаатайгаар олгогдсон. Нийт ипотекийн зээлийн

үлдэгдлийн 71.3 хувь нь 16-20 жил, 17.2 хувь нь 11-15 жил, 9.6 хувь нь 6-10 жил, 1.8 хувь нь 1-5 жилийн хугацаатай байна.



### Зээлийн хүү

Банкуудын 2015 оны 12 дугаар сард олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж 8.8 хувь байв. “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр” хэрэгжиж эхлэхээс өмнөх үетэй харьцуулахад жигнэсэн дундаж хүү 7.8 нэгж хувиар буурсан байна.



Банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 10.8 хувь байв.

## Хавсралт 1. Банкуудын ипотекийн зээлийн тайлан

Он	Сар	Ипотекийн зээлийн үлдэгдэл (сая төг.)	Үүнээс:		Тухайн сард олгосон зээлийн ЖДХүү, жилээр (%)	Нийт зээлдэгч (тоогоор)	Үүнээс:	
			ОСИССТБ хөтөлбөрийн зээл	Тайлант сард шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хугацаа (сараар)			ОСИССТБ хөтөлбөрийн зээлтэй	
2008	12	217,977.5			100.7	19.8	16,522	
2009	12	226,040.6			103.4	18.7	16,784	
2010	12	333,776.6			115.0	16.0	16,700	
2011	12	669,662.8			154.3	14.8	26,869	
2012	12	845,204.4			155.5	15.3	29,887	
2013	12	1,938,945.3	1,248,633.8		192.8	9.9	48,320	30,600
2014	1	2,021,424.9	1,324,898.9		194.4	9.8	49,731	32,190
	2	2,121,802.6	1,382,084.1		193.2	9.9	53,611	33,346
	3	2,193,368.6	1,451,938.1		190.7	9.9	54,787	34,632
	4	2,280,503.5	1,538,506.8		192.1	9.8	56,137	36,081
	5	2,365,349.5	1,618,127.2		189.3	10.0	57,579	37,488
	6	2,440,007.1	1,684,583.9		182.3	10.5	58,793	38,659
	7	2,492,105.2	1,728,222.8		187.9	10.7	59,756	39,507
	8	2,553,827.2	1,780,078.3		186.7	10.5	60,851	40,405
	9	2,619,161.1	1,833,494.0		185.9	10.6	62,017	41,390
	10	2,703,792.6	1,903,636.6		189.3	10.4	63,652	42,772
	11	2,762,726.8	1,954,341.3		194.5	10.3	64,577	43,621
	12	2,844,706.3	2,027,952.9		200.1	9.9	66,334	45,283
2015	1	2,898,731.0	2,072,894.5		195.9	10.2	67,233	46,134
	2	2,949,116.5	2,121,339.7		198.6	9.7	68,126	47,108
	3	3,015,535.1	2,196,795.5		197.7	9.2	69,269	48,512
	4	3,082,551.7	2,263,794.5		199.2	9.6	70,498	49,691
	5	3,128,182.4	2,305,308.1		197.3	10.3	71,355	50,462
	6	3,192,029.1	2,363,999.7		197.2	9.6	72,412	51,438
	7	3,230,507.8	2,400,625.2		193.2	9.9	73,208	52,181
	8	3,267,175.5	2,433,968.6		195.1	10.0	73,949	52,858
	9	3,319,711.8	2,481,556.8		194.8	9.6	74,848	53,643
	10	3,370,510.2	2,534,505.4		202.1	9.4	75,877	54,612
	11	3,412,929.6	2,570,150.9		196.5	10.0	76,583	55,295
	12	3,432,957.6	2,590,987.6		200.0	8.8	77,105	55,830

## Хавсралт 2. Орон нутгийн банкуудын ипотекийн зээлийн тайлан

2015 оны 12 дугаар сарын байдлаар

Аймгууд	Ипотекийн зээлийн		Үүнээс ОСИСТТБХ-ийн зээл		Тухайн сард олгосон ипотекийн зээлийн ЖДХугацаа (сар)	Тухайн сард олгосон ипотекийн зээлийн ЖДХүү (жилээр)	Нийт зээлдэгчдийн тоо	Үүнээс: ОСИСТТБХ хөтөлбөрийн зээлтэй
	Үлдэгдэл (сая төг.)	Эзлэх хувь	Үлдэгдэл (сая төг.)	Эзлэх хувь				
1 Улаанбаатар	2,644,518.1	77.0%	1,960,001.1	75.6%	201.6	8.9	52391	52,477
2 Дархан-Уул	115,670.6	3.4%	101,801.2	3.9%	202.2	9.3	3409	300
3 Орхон	109,778.8	3.2%	96,259.5	3.7%	195.4	8.5	2902	289
4 Дорноговь	71,220.1	2.1%	59,029.7	2.3%	230.6	8.0	2057	405
5 Дорнод	49,407.4	1.4%	44,369.7	1.7%	208.8	7.9	1562	269
6 Сэлэнгэ	46,272.3	1.3%	36,711.2	1.4%	214.5	8.6	1578	148
7 Увс	45,686.9	1.3%	33,413.3	1.3%	203.5	9.0	1483	183
8 Өвөрхангай	43,313.1	1.3%	30,799.2	1.2%	200.9	9.4	1530	144
9 Өмнөговь	41,494.4	1.2%	31,569.4	1.2%	168.1	11.3	1159	180
10 Ховд	33,390.9	1.0%	28,140.7	1.1%	202.9	7.8	1114	194
11 Баянхонгор	30,182.4	0.9%	26,685.9	1.0%	177.4	8.0	846	271
12 Сүхбаатар	26,588.8	0.8%	17,958.6	0.7%	198.8	8.1	904	140
13 Архангай	24,107.7	0.7%	19,070.1	0.7%	215.1	8.7	707	109
14 Баян-Өлгий	22,431.5	0.7%	11,929.0	0.5%	177.1	8.6	1088	59
15 Говь-Алтай	19,483.7	0.6%	15,811.9	0.6%	172.4	7.8	628	100
16 Завхан	18,934.1	0.6%	12,023.7	0.5%	128.7	7.9	703	78
17 Хөвсгөл	17,928.0	0.5%	9,670.4	0.4%	143.3	10.0	725	69
18 Хэнтий	17,166.0	0.5%	14,748.7	0.6%	170.6	8.5	510	148
19 Төв	15,253.2	0.4%	11,390.3	0.4%	197.8	8.0	475	85
20 Дундговь	15,014.7	0.4%	11,672.9	0.5%	208.3	8.0	477	79
21 Говьсүмбэр	12,691.7	0.4%	11,295.2	0.4%	186.4	7.4	412	58
22 Булган	12,423.5	0.4%	6,636.0	0.3%	128.3	8.4	445	45
<b>Нийт</b>	<b>3,432,957.6</b>	<b>100%</b>	<b>2,590,987.6</b>	<b>100%</b>	<b>200.0</b>	<b>8.8</b>	<b>77105</b>	<b>55830</b>

2015 оны 12 дугаар сарын байдлаар банкуудын ипотекийн зээлийн үлдэгдлийн 77.0 хувийг Улаанбаатар хотод, 23.0 хувийг хөдөө орон нутагт олгосон ипотекийн зээл бүрдүүлжээ. Хөдөө орон нутаг дахь ипотекийн зээлийн үлдэгдлийн 14.7 хувь буюу 115.7 тэрбум төгрөг Дархан-Уул аймагт, 13.9 хувь буюу 109.8 тэрбум төгрөг Орхон аймагт, 9.0 хувь буюу 71.2 тэрбум төгрөг Дорноговь аймагт ногдож байна.